



MNS ISO/IEC 17020:2013 стандартад итгэмжлэгдсэн байгууллага
РАДИО ДАВТАМЖ, ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХЯНАЛТЫН ТӨВ



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ШУДАРГА БАЙДЛЫН МЭДЭГДЭЛ

Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төв /цаашид “Төв” гэх/ нь MNS ISO/IEC 17020:2013 стандартын шаардлагыг хэрэгжүүлэгч техникийн хяналтын байгууллагын хувьд хараат бус, шударга, ил тод, мэргэжлийн үйл ажиллагааг ханган ажиллахыг эрхэм зорилгоо болгон дараах амлалтыг албан ёсоор мэдэгдэж байна.

Төв нь техникийн хяналтын бүх үйл ажиллагааг гуравдагч этгээдийн аливаа нөлөөлөл, дарамт шахалт, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, хараат бусаар гүйцэтгэнэ. Шударга байдал нь Төвийн үйл ажиллагааны үндсэн зарчим бөгөөд аливаа санхүүгийн, арилжааны, захиргааны болон бусад нөлөөллөөс үл хамааран үнэн бодит дүгнэлт гаргана.

Бид итгэмжлэлийг хадгалах нөхцөл, шалгуур, стандартын шаардлагатай бүрэн танилцсан бөгөөд итгэмжлэлийн холбогдох дүрэм, журам, зааврыг чанд мөрдөн ажиллана.

Техникийн хяналтын явцад олж авсан гуравдагч этгээдийн мэдээлэл, баримт бичгийн нууцлалыг хууль тогтоомж болон стандартын шаардлагын дагуу чанд хадгалж, зөвшөөрөлгүйгээр задруулахгүй.

Төв нь техникийн хяналтын үйл ажиллагааг үйлчлүүлэгчийн хэлбэр, өмчийн төрөл, байршил, хэмжээ зэргээс үл хамааран ялгаварлан гадуурхахгүйгээр ижил тэгш, шударга зарчмаар гүйцэтгэнэ.

Энэхүү шударга байдлын мэдэгдлийг Төвийн удирдлага болон бүх ажилтан, албан хаагчид дагаж мөрдөнө.

Б.БАТБАЯР

РАДИО ДАВТАМЖ, ӨРГӨН
НЭВТРҮҮЛГИЙН
ХЯНАЛТЫН ТӨВИЙН
ДАРГА